



ДУНДГОВЬ АЙМАГ  
ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 4/22

Улаан жирэм

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3 /а/, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.7, 4.5.9, ХХААХҮ-ийн сайдын 2010 оны А/67 тоот тушаал, Мал эмнэлгийн газар, улсын байцаагчийн дүгнэлт зэргийг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Бүлээн багийн Мэнгэт хэмээх газар малчин Д.Батхуягийн үхсэн үхэрт хийсэн мал эмнэлгийн лабораторийн шинжилгээгээр галзуу өвчтэй байсан нотлогдсон тул тус газарт 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Хязгаарлалтын бүсийг өвчин тогтоогдсон газраас 5 км радиуст тогтоож, тухайн өвчинтэй тэмцэх болон дэглэм тогтоосон зааврын дагуу хүн, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хүн малд ариутгал, халдвартгүйжүүлэлт хийх, дэглэм сахиулах, хяналт тавьж ажиллахыг сумын Гамшгаас хамгаалах орон тооны бус штабт /Ө.Өсөхжаргал/, /Улсын байцаагч Ц.Мөнхсүх/, Эрүүл мэндийн төвийн дарга /Э.Уранчимэг/, багийн Засаг дарга /Д.Төгсжаргал/ нарт үүрэг болгосугай.

3.Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсийн зураглал хил, хязгаарыг хавсралтаар баталсугай.

4.Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс болон тус багийн үхэр, тэмээг вакцинжуулах, хязгаарлалтын дэглэмийн талаар олон нийтэд мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг МЭҮТасаг /Ц.Мөнхсүх/, “Говь далай жаргалант” ХХК-ний малын эмч /Н.Батгэрэл/, багийн Засаг дарга /Д.Төгсжаргал/, БИНХ-ын дарга /Л.Оюунбилэг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.ЗОРИГТБААТАР

04.06.2018